



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/295

Булган



Гэрээ шууд байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2018 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан Цагдаагийн газарт тусгай тоноглол бүхий автомашин нийлүүлэх "Тайсуман" ХХК-тай гэрээ шууд байгуулахыг Цагдаагийн газар /З.Гомбо/-т шилжүүлсүгэй.

2. Дээрх ажил үйлчилгээг хийх аж ахуйн нэгжтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, батлагдсан төсөвт багтааж хийх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Б.Одхүү/-т үүрэг болгосугай.

3. Тус ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ